МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2016.02.05 № 3/140

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

/ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ч.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын батлсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ЭНХЗАЯА

УХА0122

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	97,751,278.10	124,750,076.76
2	Кассанд байгаа бэлэн мөнгө	976,846.00	255,777.00
3	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	96,774,432.10	124,494,299.76
7	АВЛАГА	6,454,748.83	54,495,826.64
8	Үндсэн үйл ажиллагааны авлага	-	54,495,826.64
9	Бусад авлага	6,454,748.83	-
10	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	415,354.93	-
12	Урьдчилж гарсан зардал	415,354.93	-
13	БАРАА МАТЕРИАЛ	4,394,588.00	892,555.40
14	Түүхий эд материал	781,000.00	319,000.00
17	Хангамжийн материал	3,612,588.00	573,555.40
19	Бусад	1,000.00	-
21	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,015,969.86	180,138,458.80
22	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,702,015.44	101,677,062.19
24	Биет хөрөнгө	115,210,557.18	96,455,048.47
27	Авто тээврийн хэрэгсэл	75,400,000.00	75,400,000.00
28	Хуримтлагдсан элэгдэл	(8,602,499.96)	(16,142,499.92)
29	Машин, тоног төхөөрөмж	36,597,359.00	39,294,359.00
30	Хуримтлагдсан элэгдэл	(18,653,263.55)	(28,154,522.02)
31	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,698,100.00	36,698,100.00
32	Хуримтлагдсан элэгдэл	(7,100,051.58)	(11,478,701.82)
38	Номын фонд	52,540.00	52,540.00
39	Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
40	Хуримтлагдсан элэгдэл	(51,616.73)	(84,216.77)
42	Биет бус хөрөнгө	491,458.26	5,222,013.72
43	Програм хангамж	830,000.00	5,880,000.00
44	Хасагдуулга	(338,541.74)	(657,986.28)
48	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	115,702,015.44	101,677,062.19
49	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	224,717,985.30	281,815,520.99
50	Богино хугацаат өр төлбөр	9,373,207.68	10,510,897.60
51	Өглөг	9,373,207.68	10,510,897.60
52	Ажиллагчидтай холбогдсон өглөг	9,373,207.68	(0.00)
57	Бусад өглөг	-	10,510,897.60
61	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,373,207.68	10,510,897.60
64	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,373,207.68	10,510,897.60
66	Өмнөх үеийн үр дүн	215,344,777.62	215,344,777.62
67	Тайлант үеийн үр дүн	-	55,959,845.77
69	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	215,344,777.62	271,304,623.39
70	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	224,717,985.30	281,815,520.99